

ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ-3

АМЬДРАЛЫН ХЭВШИЛ, НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХАМГААЛАЛ

Тайланг боловсруулсан:
Загирын Тогтохмаа(PhD)

Мэдээлэл цуглуулсан баг:
ХИС-гийн Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн ажилтнууд
ХИС-гийн Говь-Алтай, Ховд аймаг дахь салбарын ажилтнууд

Хянан тохиолдуулсан баг:
ХИС-гийн Хүүхэд хамгаалал хөтөлбөрийн ажилтнууд

“Сургуультай хамтран Хүүхэд хамгааллыг сайжруулах нь” (2023-2025 он) төслийн хүрээнд боловсруулав.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол
Улс | Утас: +976-11-329371, 329365| Факс: +976-11-329361|
Цахим шуудан: Mongolia.secretary@savethechildren.org |

“Өсвөр үеийнхний дуу хоолой”судалгааны тайлангуудыг Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр, тус газрын дэргэдэх Хүүхэд хамгааллын аргазүйн төвөөс болон цахим хэлбэрээр www.savethechildren.mn; <https://resourcecentre.savethechildren.net/> вэб хуудсаас авах боломжтой.

АГУУЛГА

Судалгааны хураангуй үр дүн	5
Судалгааны танилцуулга	8
Судалгааны үр дүн	10
Нэгдүгээр бүлэг: Хүүхдүүд, амьдралын хэвшил, сэтгэл санааны төлөв	10
Хоёрдугаар бүлэг: Хүүхдүүд, сургууль, хамгаалал	14
Гуравдугаар бүлэг: Хүүхдүүд, хамгааллын талаарх тэдний санал бодол	21
Судалгааны дүгнэлт, санал зөвлөмж	26
Хавсралт	29

ӨМНӨХ ҮГ

Хүүхэд нас, хөгжлийн онцлогтоо тохируулан өөрт хамаатай бүхий л асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх эрхийг Хүүхдийн эрхийн тухай конвенцоор бататгасан нь аливаа шийдвэрийг тэдний дээд ашиг сонирхолд нийцүүлэн гаргах үндэс болдог билээ. Энэ эрх нь гэр бүл, сургууль, нийгмийн бусад орчин, оршин сууж буй газар гэх мэт хаана ч, ямар ч түвшинд хэрэгжих ёстой, үүнийг хангах нь насанд хүрэгчдийн үүрэг, хариуцлага юм.

Монгол Улсын нийт хүн амын 36.2% нь 19 хүртэлх насны хүүхдүүд байгаагийн 57.7% нь 10-19 хүртэлх насны өсвөр насныхан байна. Тэдгээр хүүхдээс тодорхой асуудлын талаар ямар санаа бодолтой байгаа, тэдний нөхцөл байдал ямар байгааг асууж мэдэх нь тэдэнд чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны санаа, загварыг боловсруулахад нэн чухал.

“Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаа нь цувралаар гардаг, цуврал тус бүр нь тодорхой нэг сэдэв, асуудалд чиглэдэг. Эхний судалгаа нь гэр бүл, сургууль, олон нийт гэх мэт нийгмийн бүхий л орчин дахь хүүхэд хамгааллын асуудалд чиглэсэн бол, хоёр дахь нь шударга ёс, авлигын асуудалд төвлөрчээ. Энэ удаагийн судалгаа нь гурав дахь цуврал бөгөөд үүгээр өсвөр насны хүүхдүүдийн амьдралын өдөр тутмын хэвшил, сэтгэл санааны төлөв, хамгааллын нөхцөл байдлыг тодрууллаа. Цуврал судалгааны онцлог нь судалгааны бүх үр дүнг нэг бүрчлэн тайлбарладаггүй, харин гол, гол үр дүнг онцлох бөгөөд ингэхдээ хүн бүрд, нэн ялангуяа хүүхдэд ойлгомжтой, тодорхой байхаар энгийн шинжилгээ хийхийг зорьдог. Онцолсон үр дүнгүүдийг тайланд ихэвчлэн харьцуулсан графикаар харуулдаг бол хавсралтаар бүх мэдээллийг анги, хүйс, байршлаар ялган хүснэгтээр оруулдаг нь тэдгээрийг нарийвчлан шинжлэх боломжийг судлаач, сонирхогчид, хүүхдүүдэд олгодог билээ.

“Өсвөр үеийнхний дуу хоолой 3: Амьдралын хэвшил, нөхцөл байдал, хамгаалал” энэхүү гурав дахь цувралын тайлантай танилцан, санал бодлоо бидэнд илгээвэл талархан хүлээн авах болно. Энэ удаагийн цувралыг “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл (2023-2025)-ийн хүрээнд гүйцэтгэснийг дурдахад таатай байна.

Японы Хүүхдийг Ивээх Ивээх Сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ҮР ДҮН

Нэгдүгээр бүлэг: Хүүхдүүдийн амьдралын хэвшил, сэтгэл санааны төлөв



Хүүхдүүдийн 65.6% нь өглөөний цайгаа уудаг, 33.2% нь үгүй, 1.2% нь заримдаа уудаг гэж хариулжээ. Анги дэвших тусам өглөөний цайгаа уудаггүй хүүхдүүдийн тоо нэмэгдэж байна.



Хүүхдүүдийн 37.3% нь 23:00-23:59, 28.3% нь 24:00-01:59, 22.7% нь 22:00-22:59 цагийн хооронд унтахаар орондоо ордог. Харин 38.7% нь 07:00-07:59, 31.9% нь 06:00-06:59 цагийн хооронд босдог. Хүүхдүүдийн 53.4% нь нэг хоногт 5-7 цаг унтдаг аж.



35.3% нь сэтгэл санаа сайхан байна гэсэн бол 23.3% хэвийн, 16.2% нь тааруу байна гэж хариулжээ.



41.9% нь хичээл, шалгалт, дүнгээс болж санаа зовж буйгаа илэрхийлсэн бол 21% нь санаа зовох зүйл байхгүй гэжээ. Түүнчлэн, 4.9% ирээдүйдээ, 4.5% нь нийгэмдээ санаа зовж буйгаа илэрхийлсэн.



Хүүхдүүдийн 18% нь нэг өдөрт 2-3 цаг, 17.6% нь 4-5 цаг, 15.6% нь 3-4 цаг, 13.6% нь 1-2 цаг, 9% нь 6-8 цагийг тус тус интернэтэд зарцуулдаг гэжээ.



87.3% нь уншдаг, үүний 34% нь сурах бичиг, 53.3% нь сурах бичгээс бусад уран зохиол, түүхийн ном уншсан гэжээ. Ном уншдаггүй гэж хариулсан хүүхдүүд нийт хүүхдийн 4.7%-ийг эзэлж байна.



Амрах арга хэлбэрийн хувьд хүүхдүүдийн 42.8% нь унтах, хэвтэх, 10.2% нь дуу сонсох, 7.2% нь дуртай зүйлээ хийх хэмээн нэрлэсэн нь хамгийн олонх болж байна.

Хоёрдугаар бүлэг: Сургуулийн орчин, хүүхэд хамгаалал



Нийт хүүхдийн 55.7% нь хичээлийн их завсарлагаагаар юм идэж амждаг гэсэн бол 42.3% нь үгүй, 2% нь заримдаа амждаг гэжээ.



76% нь сургуулийн цайны газраас юм авч иддэг, 22.5% нь юм авч иддэггүй гэжээ. Идэх юм авдаг гэж хариулсан хүүхдүүдийн 50.1% нь хуушуур, пирожки, кимбаб, мантуун бууз зэрэг бэлэн хоол авдаг гэсэн бол 9.9% нь идэх, уух зүйлсийг хамтад нь авдаг аж.



Сургуулийн ойролцоох дэлгүүрээс юм авдаг гэж 86.4% нь хариулсан бол 11.5% нь авдаггүй гэжээ. Харин дэлгүүрээс юм авдаг хүүхдүүдийн 85.1% нь чипс, пирожки, ороомог, ундаа зэрэг бэлэн хоол, амттан авдаг гэж хариулжээ.

	Сургууль дээрээ ус, цай гэх мэт шингэн зүйл уудаг эсэхийг тодруулахад 63.5% нь хариулсан бөгөөд үүний 23.5% нь тогтмол уудаг, 13.6% нь уудаг, 4.2% нь маш бага уудаг, 4.1 заримдаа уудаг гэсэн бол 17.2% нь уудаггүй гэжээ.
	Нийт сурагчийн 58.2% нь завсарлагаагаар бие засаж амждаг бол 32.5% нь амждаггүй, 8.6% нь заримдаа амждаггүй гэжээ. Харин 0.7% нь ариун цэврийн өрөө маш бохир тул бие засдаггүй гэж хариулсан байна.
	Сургуулийн бие засах газарт ариун цэврийн цаас, саван байдаг эсэхийг лавлахад, нийт оролцогчийн 77.2% нь байдаггүй, 10.7% нь заримдаа байдаг гэжээ.
	Сургууль дээр хүүхэд гэмтэх, бэртэх эрсдэлтэй зүйл байдаг уу гэсэн асуултад нийт оролцогчийн 49.1% нь тийм зүйл байхгүй гэсэн бол 8.9% нь хариулаагүй, 6% нь мэдэхгүй гэжээ. Үлдсэн хүүхдүүдийн хувьд 20.3% нь байдаг гэсэн ч хаана, юу байдгийг тодорхой нэрлээгүй, харин 11.4% нь сургуулийн гадна эрсдэлтэй зүйл бий гэсэн бол 3.5% нь сургууль дотор тийм зүйл бий гэжээ.
	Гэрээс сургууль хүртэлх замд аюул, эрсдэл байдаг эсэхийг тодруулахад, ямар нэг эрсдэл, аюул байхгүй гэж нийт хүүхдийн 41.7%, байдаг гэж 47.2%, мэдэхгүй гэж 1.9% нь хариулсан бол 9.2% нь хариулаагүй. Гэрээс сургууль хүртэлх замд аюул, эрсдэл бий гэж хариулсан хүүхдүүд нохой, авто замын хөдөлгөөн, согтуу болон танихгүй хүн, гэрэлтүүлэг, барилгыг нэрлэжээ.
	Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс хэн нэгэнд дээрэлхүүлдэг эсэхийг лавлахад, 78.7% нь үгүй гэсэн бол 14.7% нь тийм, 0,9% нь хааяа гэжээ.
	Хүүхдүүд өөрсдийг нь “анхаарах, дэмжих, сонсох, ярилцах, туслах”-ыг ангийн багш, бусад багш, нийгмийн ажилтан, сургалтын менежерээс хүсдэг аж. Харин сургуулийн тогооч, үйлчлэгч, жижүүр, манаачаас аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэхийг голлон хүсдэг байна.
	Сургуулийнхаа юунд хамгийн дуртай вэ гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 23.8% нь сургуулийн байр, орчин гэсэн бол 11.1% нь багш, ажилтнууд, тэдний харьцаа, 8.7% нь хичээл, суралцах орчин гэж хариулсан бол бүх зүйл нь сайхан гэж 7.7% нь үзжээ.
	Сургуулийнхаа юуг өөрчлөх хүсэлтэй байгааг лавлахад, өөрчлөх зүйлгүй гэж нийт хүүхдийн 13% нь хариулсан бол 2.8% нь мэдэхгүй гэж, 11.9% нь хариулт өгөөгүй байна. Өөрчлөхөөр нэрлэсэн зүйлс нь голдуу сургуулийн байр, орчин, тав тух, цэвэр байдал, анги танхимын дотоод тохижилт гэсэн суралцах материаллаг орчинтой холбоотой байна.
	Хамгийн сайн багш гэж хэнийг хэлэх вэ гэсэн асуултад “ярилцаж ойлголцдог, асуудлыг шийдэж, дэмждэг” гэсэн шинж хамгийн их хувь (20.8)-ийг эзэлж байна.

Гуравдугаар бүлэг: Хүүхэд хамгааллын талаарх өсвөр үеийнхний санал бодол



Хүүхдийг хэн хамгаалах ёстой вэ гэсэн асуултад 42.8% нь бүх хүн гэсэн бол 43.6% нь эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийг нэрлэжээ. Хүүхдүүдийн 52.9% нь хүүхдийг анхаарч халамжлах, хайрлах (21.3%); аюулгүй, эрүүл орчин бүрдүүлэх (23.1%); зааж чиглүүлэх, зөвлөх, мэдээлэл өгөх (7.1%); зөв харилцах, үлгэр дуурайл үзүүлэх (1%); хүчирхийлэл, зүй бус үйлдлийг мэдээлэх (0.4%) нь хүүхэд хамгаалах арга юм гэжээ.



Хүүхдийг дээрэлхлээс хамгаалахын тулд хүүхдээ ойлгох, ярилцах, сонсох, цаг гаргах, харилцаандаа анхаарах, хүүхдээ чиглүүлэх, зөв төлөвшүүлэх, хараа хяналт тавих ёстой гэж хүүхдүүд үзсэн.



42.7% нь хүүхдийг чиглүүлэх, зөв төлөвшүүлэх; хүүхдээ ойлгох, ярилцах, сонсох; хүчирхийлэл, зүй бус үйлдлийг мэдээлэх гэсэн аргыг хүүхэд хамгаалах гол аргад нэрлэсэн.



Эцэг эх, эмээ өвөө, ах эгч гэх мэт гэр бүлийн гишүүн хэн байхаас үл хамааран эелдэг найрсаг, дотно хийгээд нээлттэй харилцаа чухал болохыг хариулт өгсөн 10 хүүхэд тутмын 5-6 нь онцолжээ.



Дэлгүүрийн худалдагч, орцны жижүүр, автобусанд хамт зорчигчид хүүхэдтэй найрсаг, зөв боловсон, хүндэтгэлтэй харилцах ёстойг 10 хүүхэд тутмын 6-8 нь дурджээ. Олон нийтийн газарт хүнд байдалд ороход эргэн тойрны хүмүүс тусалдаг эсэхэд 48.4% нь үгүй, 39.6% нь тийм гэсэн байна.



Цахим орчинд хүүхдэд юу хамгийн аюултай болохыг тодруулахад, 36.8% нь хуурамч хаяг, 8.9% нь цахим залилан, луйвар, 8% нь хакер, вирус, цахим халдлагыг онцгойлон нэрлэжээ.



Цахим орчны эрсдэлээс өөрийгөө хамгаалах аргыг мэдэх талаар лавлахад, 20.6% нь мэдэхгүй гэсэн бол 50.7% нь мэднэ гэсэн ч тодорхой арга нэрлээгүй. 11.7% нь цахим орчинд хувийн мэдээлээ хамгаалах тодорхой арга мэднэ гэжээ. Цахим орчинд хүүхдийг эцэг эх хамгаалах ёстой гэж 38.3%, хуулийн байгууллага гэж 8.1% нь, насанд хүрэгчид гэж 3.4% нь хариулсан. Нууцлал, мэдээлэл хамгаалалтын талаар заах, ёс зүйтэй цахим харилцааг баримтлах, үлгэрлэх, мэдлэг мэдээлэл түгээх, контент, платформыг хянах замаар хүүхдийг хамгаалах ёстой гэж тэд үзжээ.



Хурдан морь унадаг хүүхдүүдийг хэн хамгаалах вэ гэсэн асуултад 21.2% нь уяач, морины эзнийг онцолсон бол 18% нь эцэг эх, асран хамгаалагчийг нэрлэжээ. Эдгээр хүүхдийг хамгаалахын тулд хамгаалалтын хувцас хэрэглэх, морины уралдаанд хориг тавих, даатгал, хуулийн хариуцлагыг сайжруулах, насны хязгаар тогтоох, цалин хөлсийг нь сайн олгох ёстой гэжээ.



Хүүхдийн эрх зөрчигдвөл эцэг эх, асран хамгаалагч, багш, сургууль, хүүхэд хамгааллын байгууллага, тусгай дугаар, цагдаа, шүүх, бусад хүмүүст хандана гэж хүүхдүүд хариулсан.

СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

“Өсвөр үеийнхний дуу хоолой” нь Хүүхдийг Ивээх Сангаас тодорхой сэдвээр хийгддэг цуврал судалгаа юм. Эхний цувралыг 2016-2017 онд нийгмийн бүхий л орчин дахь хүүхэд хамгааллын асуудлаар 1,236 хүүхэд хамруулан хийж, “Өсвөр үеийнхний дуу хоолой 1” судалгаа гаргасан. Энэхүү судалгаагаар 3 хүүхэд тутмын 1 нь өөрт хамааралтай, тэр дундаа боловсрол, сургуулийн орчинтой холбоотой асуудлаар санал бодлоо илэрхийлж, нөлөөлөх хүсэлтэйгээ илэрхийлсэн байдаг. Түүнчлэн, хүүхдүүдийн 53.4% нь сургуулийн орчинд дарамт, хүчирхийлэлд өртдөг гэсэн дүн уг судалгаанаас гарсан. Энэ нь боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулах, тухайлбал, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх цогц механизмыг олон талт оролцоонд суурилан бүрдүүлэх шаардлагатайг харуулсан билээ. Хүүхдийг Ивээх Сан энэ чиглэлээр тууштай ажиллаж ирсний нэг тод жишээ нь 2023-2025 онд хэрэгжиж буй “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл юм. Төслийн хүрээнд сургуулийн багш, ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчид, сурагчид болон хамтарсан багийн оролцоо бүхий сургуульд суурилсан хүүхэд хамгааллын механизмыг бүрдүүлж, үр дүнтэй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх хамтын ажиллагааны загвар бий болгох зорилготой.

Хоёр дахь цуврал судалгааг шударга ёс, авлига, ашиг сонирхлын талаарх өсвөр үеийнхний ойлголт, хандлагыг тодруулах чиглэлээр хийж, Архангай, Дорнод, Говьсүмбэр, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв аймаг болон Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулиудын 6, 8, 10-р ангийн 2,191 хүүхдийг судалгаандаа хамруулжээ.

Харин гурав дахь буюу энэхүү цуврал судалгаагаар сургууль болон нийгмийн бусад орчин, тэр дундаа цахим орчин дахь хамгааллын асуудлуудаас гадна хүүхдүүдийн өдөр тутмын амьдралын хэмнэл, хэвшлийг тодруулахаар зорьсон билээ. Хүүхдүүдийн суралцах чадвар, эрүүл мэнд, урт хугацаандаа амьдралын чанарт нь нөлөөлөх чухал хэвشلүүд болох унтах, идэх, амрах хэмнэлийг тогтоосноос гадна сургууль дахь ялгаатай үүрэг бүхий хүмүүс хүүхэд хамгаалалд хэрхэн оролцох ёстойг харуулсан судалгаа болсноороо өмнөх цувралууд, ялангуяа эхнийхээс ялгаатай. Энэхүү цуврал судалгааг өмнө дурдсан “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд гүйцэтгэж буй бөгөөд боловсролын орчинд хүүхэд хамгааллын хамтын механизмыг бүрдүүлэхэд тус судалгаа нь зохих хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.


Судалгааны зорилгын хүрээнд 40 орчим асуултыг боловсруулахдаа дараах гурван үндсэн зарчмыг баримталсан:

- Тодорхой асуултуудыг нээлттэй төгсгөлтэй байдлаар боловсруулж, хариултын хувилбар санал болгохгүйгээр хүүхдүүдийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг бүрдүүлэх;
- Асуултуудыг энгийн, ойлгомжтой байлгахын зэрэгцээ “яагаад” гэхээс илүүтэйгээр “юу”, “ямар”, “яаж” гэсэн асуултуудаар мэдээлэл цуглуулах, ингэснээр олон хүүхдээс өргөн хүрээний мэдээлэл авах боломжтой болох ба цаашдын судалгааны асуулт, хариултын хувилбаруудыг бүрэн гүйцэд боловсруулаад ашиглах;

Зарим асуултыг нь хоорондоо давхацсан байдлаар төлөвлөх, ингэснээр тухайн асуудлаар хүүхдүүд ижил хариу өгч буй эсэхийг давхар шалгах. Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 51, 73; Баянзүрх дүүргийн 33, 48; Сүхбаатар дүүргийн 2, 58; Чингэлтэй дүүргийн 17, 50; Хан-Уул дүүргийн 7, 130-р сургууль; мөн Говь-Алтай аймгийн 4-р сургууль, Дарив сумын сургууль, Ховд аймгийн 1-р сургууль, Дарви сумын сургуулийг энэхүү судалгаанд хамруулахаар сонгосон нь “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн зорилтот орон нутагт хамаарч байсантай холбоотой юм.


Судалгааны мэдээллийг 2023-2024 онд Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн ажилтнууд тухайн орон нутгийн холбогдох хүмүүсийн тусламжтайгаар цуглуулсан болно.

Судалгааны бүх мэдээллийг нээлттэй байдлаар авсан тул дүн шинжилгээ хийхэд нэлээд их хугацаа зарцуулсан. Эхлээд судалгааны бүх мэдээллийг эксел програмд нэг бүрчлэн шивж оруулсан. Дараа нь асуулт тус бүрээр судалгаанд оролцогчдын хариултуудыг шүүж, ижил болон давхардсан шинжээр нь бүлэглэн ангилсан. Бүлэглэсэн мэдээллийг “SPSS” програмд оруулж, кодлон, дүн шинжилгээ хийсэн болно.



Судалгаанд Улаанбаатар хотын ерөнхий боловсролын 10, Говь-Алтай, Ховд аймгийн 4, нийт 14 сургуулийн 6-12-р ангийн 1,342 сурагчийг хамруулсан. Судалгаанд оролцогчдын 46% нь эрэгтэй, 54% нь эмэгтэй. 19.6% нь 6-7-р анги, 43.7% нь 8-9-р анги, 36.7% нь 10-12-р ангийн сурагчид байлаа. 6-7-р ангийн хүүхдүүд 12-13 настай, 8-9-р ангийн хүүхдүүд 14-15 настай, 10-12-р ангийн хүүхдүүд 16-18 настай байв.

Нийт оролцогчийн 54.5% нь хотын, 45.5% нь хөдөөгийн сургуулийн сурагчид байна. Хөдөөтэй харьцуулахад, хотын эмэгтэй хүүхдүүд болон 8-9-р ангийнхан илүү их хувиар судалгаанд оролцжээ.



Судалгааны үр дүнг дараагийн хэсэгт үзүүлэв.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН


1

ХҮҮХДҮҮДИЙН АМЬДРАЛЫН ХЭВШИЛ, СЭТГЭЛ САНААНЫ ТӨЛӨВ

Энэ бүлэгт өглөөний цайгаа тогтмол уудаг эсэх, унтах, босох цаг, сэтгэлийн зовуурь, гар утас, интернэтийн хэрэглээ, ном унших, амардаг арга гэх мэт хот, хөдөөгийн өсвөр насны хүүхдүүдийн амьдралын өдөр тутмын хэвшил, сэтгэл санааны төлөвийг энэ бүлэгт тодруулан авч үзсэн. Хүүхдүүдийн өдөр тутмын амьдралын хэвшил нь тэдний суралцах чадвар, эрүүл мэндээс гадна урт хугацаанд амьдралын чанарыг нь тодорхойлох суурь үзүүлэлт болдог учраас бид эдгээр асуудлыг энэ судалгаанд багтаасан билээ.


Өглөөний цайгаа уудаг уу гэсэн асуултад нийт сурагчийн 65.6% нь тийм, 33.2% нь үгүй, 1.2% нь заримдаа уудаг гэж хариулжээ. Анги дэвших тусам өглөөний цайгаа уудаггүй хүүхдүүдийн тоо нэмэгдэж байна (Зураг 1.1). Тодруулбал, 6-7-р ангийн 55 (тус ангийн бүлгийн 21%, нийт хүүхдийн 4%), 8-9-р ангийн 189 (тус ангийн бүлгийн 32%, нийт хүүхдийн 14%), 10-12-р ангийн 201 (тус ангийн бүлгийн 41%, нийт хүүхдийн 15%) хүүхэд өглөөний цай уудаггүй аж. Өглөөний цайгаа уудаггүй гэж хариулсан 445 хүүхдүүдийн 51.6% нь хотынх, 48.4% нь хөдөөгийнх байна.

Зураг 1.1. Өглөөний цай уудаггүй хүүхдүүд



Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 37.3% нь 23:00-23:59 цагийн хооронд, 28.3% нь 24:00-01:59 цагийн хооронд, 22.7% нь 22:00-22:59 цагийн хооронд унтахаар орондоо ордог. Эдгээр нь нийт хүүхдийн 88%-ийг эзэлж байгаа бөгөөд дийлэнх хүүхдийн орондоо орж, унтах цаг нь 23-аас шөнийн 2 хүртэлх цагийн хооронд хэлбэлзэж байнадэг гэсэн үг. Олонх хүүхдийн унтахаар орондоо ордог цагийг хүйс, анги, байршлаар ялган харвал, эмэгтэй хүүхдүүд, түүнчлэн 6-7 болон 10-12-р ангийнхан илүү оройтож орондоо ордог хандлага ажиглагдаж байна (Зураг 1.2).

Зураг 1.2. Унтахаар орондоо ордог цаг




Хамгийн их хувийг эзэлж буй 23:00-23:59 цагийн хооронд орондоо ордог хүүхдүүдийг судалгаанд оролцсон нийт хүүхэдтэй харьцуулж үзвэл, 17% нь 8-9-р ангийнхан, 13% нь 10-12-р ангийнхан, 7% нь 6-7-р ангийнхан байна. Харин нийт хүүхэдтэй харьцуулахад, энэ цагт орондоо ордог хотын хүүхдүүд 18.8% бол, хөдөөгийн хүүхдүүд 18.4% -тай байна.

Өглөө босдог цагийн хувьд, судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 38.7% нь 07:00-07:59 цагт босдог бол 31.9% нь 06:00-06:59 цагийн хооронд байна. Энэ нь нийт хүүхдийн 70.6% эзэлж байна. Хөдөөгийн хүүхдүүдийн 85.2%, хотын хүүхдүүдийн 58.4% нь дээр дурдсан хоёр цагийн хүрээнд босдогийг судалгааны үр дүн илтгэж байна. Тухайн бүлэг дунд нь авч үзвэл, 6-7-р ангийнхны 42.6%, 8-9-р ангийнхны 35.6%, 10-12-р ангийнхны 40.4% нь өглөө 07:00-07:59 цагийн хооронд босдог аж (Зураг 1.3). Хөдөөгийн хүүхдүүд хотынхоос эрт босдог нь зургаас тодорхой харагдаж байна. Мөн эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдүүдээс илүү эрт босдог аж.

Өмнөх үр дүнтэй холбон авч үзвэл, 6-7-р ангийнхны дунд бусдаас оройтож унтах, эрт босох хандлага түгээмэл байна.


Зураг 1.3. Өглөө босдог цаг



Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 53.4% нь нэг хоногт 5-7 цаг унтдаг байнааж. Өсвөр насны буюу 13-18 насны хүүхдүүд нэг хоногт 8-10 цаг унтвал хэвийн хөгжил, төлөвшилд тустай болохыг судлаачид дүгнээд¹ буйтай холбон авч үзвэл энэхүү гуравдугаар цуврал судалгаанд хамрагдсан хүүхдүүд даруй 3 цагаар бага унтаж байгаа нь харагдаж байна.

1 <https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC5078711/>


Зураг 1.4. Сэтгэл санааны төлөв



Судалгааны мэдээлэл цуглуулсан өдрөөр баримжаалан сэтгэл санааны төлөв байдлыг тандахад, нийт хүүхдийн 35.3% нь сайхан байна гэсэн бол 23.3% хэвийн, 16.2% нь тааруу гэж хариулжээ (Зураг 1.4). Хөдөөгийн хүүхдүүдтэй харьцуулахад хотын хүүхдүүдийн сэтгэл санаа таагүй байх нь өндөр хувьтай байгаа бол зөвхөн 6-7-р ангийн хүүхдүүдийн сэтгэл санааны төлөв бусад ангийхнаас илүү таагүй байх хандлагатай байна. Өмнөх үр дүнгүүдтэй холбон авч үзвэл, 6-7-р ангийн хүүхдүүдийн энэхүү сэтгэл санааны төлөвт тэдний оройтож унтаад эрт босдог хандлага нөлөөлсөн байх талтай.

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 41.9% нь хичээл, шалгалт, дүнгээс болж санаа зовж буйгаа илэрхийлсэн бол 21% нь санаа зовох зүйл байхгүй гэжээ. Түүнчлэн, 4.9% ирээдүйдээ, 4.5% нь нийгэмдээ санаа зовж буйгаа илэрхийлсэн. Хичээл, шалгалт, дүндээ санаа зовж байна гэсэн хүүхдүүдийг харвал (Зураг 1.5), хот, хөдөө, хүйсээр онцын ялгаагүй, сонирхолтой нь бусад ангийнхантай харьцуулахад, 10-12-р ангийн хүүхдүүд хичээл, шалгалт, дүндээ санаа зовох нь бага байна. Харин 8-9-р ангийн сурагчдын хувьд

Зураг 1.5. Хичээлдээ санаа зовж буй байдал




хичээлдээ бусдаас илүү их санаа зовж буй нь мэргэжил сонгох хариуцлагатай цаг үедээ явж буйтай холбоотой байх магадлалтай.

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдээс өдөрт хэдэн цагийг интернэтэд өнгөрөөдөг талаар лавлахад, 18% нь 2-3 цаг, 17.6% нь 4-5 цаг, 15.6% нь 3-4 цаг, 13.6% нь 1-2 цаг, 9% нь 6-8 цаг гэж хариулжээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Интернэтэд зарцуулдаг цаг (хувиар)

№	Интернэт ашигладаг цаг	Нийт	Хүйс		Анги			Байршил	
			Эр	Эм	6-7	8-9	Авт	Хот	Хөдөө
1	1-2 цаг	13.6	13.3	13.9	14.8	13.1	13.6	15.4	11.5
2	2-3 цаг	18.0	16.7	19.2	20.2	18.2	16.7	17.9	18.2
3	3-4 цаг	15.6	13.5	17.5	13.7	16.5	15.7	15.2	16.2
4	4-5 цаг	17.6	19.3	16.1	15.2	17.4	19.1	16.8	18.5
	Нийт	64.8	62.8	66.7	63.9	65.2	65.1	65.3	65.4

Зураг 1.6. Ном уншдаггүй хүүхдүүд



Хүснэгтээс үзвэл, анги, байршлаар төдийлөн ялгаагүй, харин хүйсийн ялгаа байгаа нь охид хөвгүүдээс илүү их цагийг интернэтэд өнгөрүүлдэг байна.


Хүүхдүүдийн 87.3% нь ном уншдаг гэсэн бөгөөд үүний 34% нь сурах бичиг, 53.3% нь сурах бичгээс өөр уран зохиол, түүхийн сэдэвт ном уншсан гэжээ. Ном уншдаггүй гэж хариулсан хүүхдүүд нийт хүүхдийн 4.7%-ийг эзэлж байна. Эдгээр хүүхдийн хооронд хүйс, анги, хот, хөдөөгөөр тодорхой ялгаа байгаа нь харагдсан (Зураг 1.6). Тодруулбал, эмэгтэй хүүхдүүд эрэгтэй хүүхдүүдээс бага уншдаг аж. Өмнөх үр дүнтэй

холбовол, хөвгүүдээс илүү охид олон цагийг интернэтэд өнгөрүүлдгээс ном унших цаг бага гардаг байж болно. Түүнчлэн, 6-7-р ангийн хүүхдүүд бусад ангийнхнаас бага уншдаг, хөдөөгийн хүүхдүүд хотынхноос бага уншдаг байна.

Хэрхэн амардаг талаар судалгаанд оролцсон хүүхдүүдээс тодруулахад, 42.8% нь унтах, хэвтэх, 10.2% нь дуу сонсох, 7.2% нь дуртай зүйлээ хийх хэмээн нэрлэсэн нь хамгийн олонх болж байна (Зураг 1.7).

Зургаас үзвэл, хүйсийн хувьд эмэгтэй хүүхдүүд эрэгтэй хүүхдээс илүү унтах, хэвтэхийг амрах хэлбэрээр сонгодог бол 8-9-р ангийнхан болон хөдөөгийн хүүхдүүд мөн аргыг илүүд үздэг аж. Судалгаанд хамрагдсан өсвөр насны хүүхдүүд эрдэмтдийн зөвлөж буйгаас даруй 3 цагаар бага унтаж байгаа талаар өмнө дурдсан. Ийм учраас алдсан нойроо нөхөх гэж тэдгээр хүүхдийн хувьд нийтлэг сонгодог амрах арга нь унтах, хэвтэх байж магад. Нөгөө талаас хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрөөх газар манай улсад ховор, тэр дундаа хөдөөд бүр ховор, хотын хувьд түгжрэлээс болж хүүхдүүд магадгүй энэ аргыг ч голчилдог байх талтай. Түүнчлэн, тун бага хувийг эзэлж буй боловч хүүхдүүдийн нэрлэсэн өөр амрах арга хэлбэрүүдэд дасгал хийх, бясалгал, иог хийх, ганцаараа байх, гэрээ цэвэрлэх, ном

Зураг 1.7. Амрах хэлбэрүүд



унших, бусадтай ярилцах, найзуудтайгаа уулзах зэрэг багтжээ.

Энэ бүлэгт бид өсвөр насны хүүхдүүдийн өдөр тутмын амьдралын хэвшлийг тодруулж, хот, хөдөө, хүйс, ангиар ялгаа буй эсэхийг харуулснаас гадна заримд нь учир шалтгааны таамаг дэвшүүлж, дүгнэлт хийлээ. Хавсаргасан хүснэгтээс энэ бүлгийн асуулт тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.

2

СУРГУУЛИЙН ОРЧИН, ХҮҮХЭД ХАМГААЛАЛ


Энэ бүлэгт бид өсвөр насны хүүхдүүдийн амьдралын дадал, хэвшлээс сургуулийн орчин дахь хамгааллын асуудлыг тодруулсан болно.

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 55.7% нь хичээлийн их завсарлагаагаар юм идэж амждаг гэсэн бол 42.3% нь амждаггүй, 2% нь заримдаа амждаг гэжээ. Үгүй гэж хариулсан хүүхдүүдийн олонх нь мөнгөгүйгээс идэх юм авдаггүй гэсэн нь завсарлагааны цаг бага байдгаас юм идэж амждаг, амждаггүй асуудал гол биш байх талтай байна. Өдөр юм идэж амждаггүй гэсэн хүүхдүүдийн 44% нь охид, 40% нь хөвгүүд бөгөөд 8-9 болон 10-12-р ангийнхны дунд өдөр юм идэж амждаггүй гэсэн хүүхэд олонх байна (Зураг 2.1). Түүнчлэн, хөдөөгийнхтэй харьцуулахад, судалгаанд оролцсон хотын хүүхдүүдийн бараг тал хувь нь өдөр юм идэж амждаггүй гэжээ.


Нийт оролцогчийн 76% нь сургуулийн цайны газраас юм авч иддэг, 22.5% нь юм авч иддэггүй гэжээ. Идэх юм авдаг гэж хариулсан хүүхдүүдийн 50.1% нь хуушуур, пирожки, кимбаб, мантуун бууз зэрэг бэлэн хоол авдаг гэсэн бол 9.9% нь идэх, уух зүйлсийг хамтад нь авдаг, 9.3% нь зөвхөн уух зүйл, 6.9% нь амттан авдаг гэжээ (Зураг 2.2). Сургуулийн цайны газраас юм авдаггүй гэсэн хүүхдүүдийн хувь анги дэвших тусам буурч байгаа бол хотынхтой харьцуулахад хөдөөгийн хүүхдүүдийн сургуулийн цайны газраас юм авах нь бага байдаг аж (Зураг 2.3). Энэ нь хөдөөгийн хүүхдүүдийн сургууль, гэр эсвэл дотуур байр хоорондоо ойрхон тул гэртээ эсвэл дотуур байрандаа очоод цайгаа уух боломжтой байдагтай холбоотой. Эсвэл эсрэгээр нь хөдөөгийн хүүхдүүд мөнгө багатайгаас юм авдаггүй ч байж болно. Юм авдаггүй гэсэн хүүхдүүдийн олонх нь мөнгө байхгүй гэсэн шалтгаан хэлсэн нь энэхүү таамаг үнэн байх магадлалыг дэмжиж байна. Гэхдээ энд сургуулийн цайны газраас юм авч иддэг, иддэггүй нь гол асуудал биш, харин худалдан авч буй идэх зүйлс нь хэр зэрэг тэжээллэг, чанартай, аюулгүй байна вэ гэдэг нь гол зүйл юм.

Сургуулийн ойролцоох дэлгүүрээс юм авдаг гэж 86.4% нь хариулсан бол 11.5% нь авдаггүй


Зураг 2.1. Өдөр юм идэж амждаггүй хүүхдүүд



Зураг 2.2. Сургуулийн цайны газраас хүүхдүүдийн авдаг зүйлс



Зураг 2.3. Цайны газраас юм авч иддэггүй хүүхдүүд



гэжээ. Юм авдаг гэсэн хүүхдүүдийн 85.1% нь мөн л чипс, пирожки, ороомог, ундаа гэх мэт бэлэн хоол, амттан авдаг гэжээ. Сургуулийн цайны газар, эсвэл ойролцоох дэлгүүр байна уу гэдгээс үл хамааран хүүхдүүдийн авч буй зүйлс ижил бөгөөд угаасаа хүүхдүүдийн боломж, нөхцөлтэй холбоотойгоор зарж буй зүйлс нь бэлэн, шууд идэхээр, жижиг, үнэ өртөг багатай бараа, бүтээгдэхүүн байдаг нь илэрхий байна. Дахин дурдахад, гол асуудал нь хүүхдүүдийн авч идэж, ууж буй зүйлсийн тэжээллэг байдал, чанар, эрүүл, аюулгүй байх нөхцөл нь хэр байна гэдгийг анхаарах нь тусдаа бодлого, зохицуулалт шаардсан зүйл юм.


Сургууль дээрээ ус, цай гэх мэт шингэн зүйл уудаг эсэхийг тодруулахад, нийт хүүхдийн 63.5% нь хариулсан. Ингэхэд 23.5% нь тогтмол уудаг, 13.6% нь уудаг, 4.2% нь маш бага уудаг, 4.1 заримдаа уудаг гэсэн бол 17.2% нь уудаггүй гэжээ (Зураг 2.4).

Сургууль дээрээ ус огт уудаггүй хүүхдүүдийг харвал, 8-9-р ангийнхан бусад ангийнхнаас өндөр хувьтай байгаа бол хүйс, хот, хөдөөгөөр төдийлөн ялгаа алга (Зураг 2.5).


Хөдөөгийн хүүхдүүдтэй харьцуулахад, хотод сургууль дээрээ ус огт уудаггүй гэсэн хүүхдүүд ялимгүй их байгаа нь тэд ойролцоох дэлгүүр, эсвэл сургуулийн цайны газраас уух зүйлс авдагтай холбоотой байх талтай бөгөөд өмнөх үр дүнг сануулахад, хотын хүүхдүүд идэх, уух зүйлс авах нь хөдөөгийн хүүхдүүдээс илүү их байсан билээ.

Судалгаанд хамрагдсан нийт сурагчийн 58.2% нь завсарлагаагаар бие засаж амждаг бол 32.5% нь амждаггүй, 8.6% нь заримдаа амждаггүй гэжээ. Харин 0.7% нь ариун цэврийн өрөө маш бохир тул бие засдаггүй гэж хариулжээ (Зураг 2.6).


Зураг 2.4. Сургууль дээрээ шингэн уудаг эсэх



Зураг 2.5. Сургууль дээрээ ус тогтмол уудаг болон ус огт уудаггүй хүүхдүүд



Зураг 2.6. Завсарлагаагаар бие засаж амждаг эсэх




Зургаас харвал, завсарлагаагаар бие засаж амждаггүй, заримдаа амждаг хүүхдүүдийн олонх нь хотын сургуулиудынх байгаа нь тэдгээр сургуулийн хүүхдийн тоо стандартаас хэтэрсэнтэй холбоотой. Бие засаж амждаггүй хүүхдүүдийн хувь анги дэвших тусам нэмэгдэж буй нь судлах хичээлийн тоо их байдаг, магадгүй зарим хичээл нь анги сэлгэж ордогтой холбоотой байж болно.

Сургуулийн бие засах газарт ариун цэврийн цаас, гар угаах саван байдаг эсэхийг лавлахад, нийт оролцогчийн 77.2% нь байдаггүй, 10.7% нь заримдаа байдаг гэжээ. Хөдөөгийн сурагчдын 93% нь бие засах газарт саван, цаас байдаггүй гэсэн бол хотын сурагчдын хувьд энэ нь 64.1%-тай байна (Зураг 2.7).


Сургууль дээр хүүхэд гэмтэх, бэртэх эрсдэлтэй зүйл байдаг уу гэсэн асуултад нийт оролцогчийн 49.1% нь тийм зүйл байхгүй гэсэн бол 8.9% нь хариулаагүй, 6% нь мэдэхгүй гэжээ. Үлдсэн хүүхдүүдийн хувьд 20.3% нь эрсдэл байдаг гэсэн ч хаана, юу байдгийг нь тодорхой нэрлээгүй, харин 11.4% нь сургуулийн гадна эрсдэлтэй зүйл бий гэсэн бол 3.5% нь сургууль дотор тийм зүйл бий гэжээ. Сургуулийн гадна болон дотор орчинд эрсдэлтэй зүйл бий гэсэн хүүхдүүдийн тоог эрсдэл бий гэсэн хүүхдүүдийн тоон дээр нэмээд, сургууль дээр эрсдэлтэй зүйл байгаа болон байхгүй гэсэн хоёр хариултад үндэслэн хүйс, анги, байршлаар ялгаж харлаа (Зураг 2.8). Ингэхэд, сургууль дээр хүүхдэд эрсдэлтэй зүйл байдаг гэж хариулсан хүүхдүүдийн тоо анги дэвших тусам нэмэгдэж буй бөгөөд эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдүүдээс, хотын хүүхдүүд хөдөөгийнхөөс илүү өндөр хувьтайгаар эрсдэлтэй зүйл сургууль дээр бий гэжээ. Анги хооронд гарч буй ялгаа нь магадгүй хүүхдүүд анги дэвшиж томрох тусам өөрт аюул, эрсдэлтэй зүйл юу болохыг илүү таньж мэддэгтэй холбоотой байж болно.

Гэрээс сургууль хүртэлх замд аюул, эрсдэл байдаг эсэх, байдаг бол юу болохыг судалгаанд оролцогч хүүхдүүдээс мөн тодруулсан. Ингэхэд, ямар нэг аюул, эрсдэл байхгүй гэж нийт хүүхдийн 41.7%, байдаг гэж 47.2%, мэдэхгүй гэж 1.9% нь хариулсан бол 9.2% нь хариулаагүй байна. Гэрээс сургууль хүртэлх замд аюул, эрсдэл бий гэж эмэгтэй хүүхдүүд, 6-7 болон 10-12-р ангийнхан, хотын хүүхдүүд илүү их хувьтай хариулжээ (Зураг 2.9).


Зураг 2.7. Бие засах газарт саван, ариун цэврийн цаас байдаггүй гэх хариултын хувилбар



Зураг 2.8. Сургууль дээр хүүхэд гэмтэх эрсдэлтэй зүйл байдаг эсэх




Зураг 2.9. Гэрээс сургууль хүрэх замд эрсдэл бий эсэх



Гэрээс сургууль хүртэлх замд аюул, эрсдэл бий гэж хариулсан хүүхдүүд нохой, замын хөдөлгөөн,

согтуу, танихгүй хүн, гэрэлтүүлэг, барилгыг тодруулан нэрлэжээ (Зураг 2.10).

Зураг 2.10. Гэрээс сургууль хүртэлх замд байх аюул, эрсдэл




Эдгээрээс нохойг хамгийн олон хүүхэд аюул, эрсдэл гэж нэрлэсэн бөгөөд үүн дотор эмэгтэй хүүхдүүд, 6-7-р ангийнхан, хөдөөгийн хүүхдүүд илүү өндөр хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс хэн нэгэнд дээрэлхүүлдэг эсэхийг лавлахад, 78.7% нь үгүй гэсэн бол 14.7% нь тийм, 0,9% нь хааяа гэжээ. “Хааяа” гэсэн хүүхдүүдийн хариултыг тийм гэсэн хариулт дээр нэмбэл энэ нь нийт хүүхдийн 15.6% болж байна. Дээрэлхүүлдэг гэж мэдээлсэн хүүхдүүдийг хүйс, анги, байршлаар тодруулан харвал (Зураг 2.11), ангиар төдийлөн ялгаагүй, харин эмэгтэй хүүхдүүд болон хотын сургуулийн хүүхдүүд бусдаас илүү өндөр хувьтай тийм гэж хариулжээ.

Сургуулийн орчинд хүүхдийг хэрхэн хамгаалах ёстой талаар бид хүүхдүүдтэй мөн ярилцсан. Ингэхэд, маш тодорхой санал хэлсэн хүүхдүүд нийт хүүхдийн 11.3%-ийг эзэлж байсан бөгөөд тэдний хэлсэн гол санааг шигтгээгээр үзүүлэв (Шигтгээ 1).

Сургуулийн орчинд хүүхдийг хэрхэн хамгаалах ёстойг сургуулийн тодорхой үүрэг бүхий ажилтнуудаар ялган тодруулсан. Эндээс хамгийн өндөр хувьтай хариултын хувилбаруудыг ялгаатай үүрэг бүхий ажилтнаар ялган харуулъя (Хүснэгт 2).

Зураг 2.11. Дээрэлхэлд өртдөг гэж хариулсан хүүхдүүд



Шигтгээ 1

- Анхаарч халамжлах
- Сонсох, ярилцах, ойлгох
- Сэтгэл санаагаар дэмжих
- Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах
- Үе тэнгийнхний дарамт, дээрэлхлээс хамгаалах
- Хууль, эрх зүйн хүрээнд хамгаалах
- Аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэх

Хүснэгт 2. Хүүхдийг хамгаалах арга замууд

Сургуулийн ажилтнууд	Хүүхдийг хамгаалах арга замууд	Хувь
Багш нар	Анхаарах, дэмжих, сонсох, ярилцах, туслах	24.1
	Аюулгүй, эрүүл орчин бүрдүүлэх	14.7
	Дээрэлхэл, хүчирхийллээс хамгаалах	10.3
Ангийн багш	Анхаарах, дэмжих, сонсох, ярилцах, туслах	34.7
	Аюулгүй, эрүүл орчин бүрдүүлэх	14.5
	Дээрэлхэл, хүчирхийллээс хамгаалах	7.4
Сургалтын менежер	Анхаарах, дэмжих, сонсох, ярилцах, туслах	16.2
	Аюулгүй, эрүүл орчин бүрдүүлэх	9.2
	Сургалт, багшийн ажлыг хянах	8.2
Нийгмийн ажилтан	Анхаарах, дэмжих, сонсох, ярилцах, туслах	25.6
	Мэдээлэл түгээх	11.5
	Аюулгүй, эрүүл орчин бүрдүүлэх	8.7
Сэтгэл зүйч	Сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө өгөх	50.9
	Хамгаалах	2.5
	Аюулгүй, эрүүл орчин бүрдүүлэх	0.8
Тогооч	Амттай эрүүл хоолоор үйлчлэх	47.8

	Анхаарал халамж тавих, туслах	4.2
	Аюулгүй орчныг бүрдүүлэх	2.0
Манаач	Аюулгүй орчныг бүрдүүлэх	33.5
	Анхаарах, халамжлах, туслах	7.2
	Эелдэг, зөв харилцах	1.9
Үйлчлэгч	Цэвэр орчин бүрдүүлэх	33.7
	Аюулгүй орчныг бүрдүүлэх	6.9
	Анхаарах, ажиглах, туслах	4.9
Жижүүр	Аюулгүй орчин бүрдүүлэх	35.8
	Хүүхдийг хянах, ажиглах	13.3
	Эелдэг, зөв харилцах	7.5

Хүснэгтээс үзвэл, хүүхдүүд өөрсдийг нь “анхаарах, дэмжих, сонсох, ярилцах, туслах”-ыг ангийн багш, бусад багш, нийгмийн ажилтан, сургалтын менежерээс хүсдэг байна. Харин сургуулийн тогооч, үйлчлэгч, жижүүр, манаачаас аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэхийг голлон хүсдэг байна. Хүүхдийг хамгаалахын тулд аюулгүй, эрүүл орчин бүрдүүлэх гэсэн санаа сургуулийн бүх ажилтнаас хүсдэг зүйлд их, бага ямар нэг хэмжээгээр багтсан байгаа нь хүүхдүүдийн хувьд “хамгаалал бол аюулгүй, эрүүл орчин” гэсэн ойлголттой байгаа нь харагдаж байна.

Сургуулийнхаа юунд хамгийн дуртай вэ гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 23.8% нь сургуулийн байр, орчин гэсэн бол 11.1% нь багш, ажилтнууд, тэдний харьцаа, 8.7% нь хичээл, суралцах орчин гэж хариулсан бол бүх зүйл нь сайхан гэж 7.7% үзжээ (Зураг 2.12).


Зураг 2.12. Сургуулиас таалагддаг зүйлс



Сургуулийн бүх зүйл нь таалагддаг гэсэн хүүхдүүдийн дундохид олонх хувийг эзэлж байгаа бол хөдөөгийн хүүхдүүд хотын хүүхдүүдээс илүү ихээр сургуулийнхаа бүх зүйлд дуртай гэжээ (Зураг 2.13). Сонирхолтой нь, 8-9-р ангийнхан бусад ангийнхнаа бодвол сургуулийнхаа бүх зүйлд дуртай байх нь бага байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдаас сургуулийнхаа юуг өөрчлөх хүсэлтэй байгааг лавлахад, өөрчлөх зүйлгүй гэж нийт хүүхдийн 13% нь хариулсан бол 2.8% нь мэдэхгүй гэж, 11.9% нь хариулт өгөөгүй байна. Харин хүүхдүүдийн 72.4% сургуулийнхаа өөрчлөх ёстой зүйлийг тодорхой нэрлэсэн байна (Зураг 2.14). Хамгийн их нэрлэсэн зүйлс нь сургуулийн байр, орчин, тав тух, цэвэр байдал, анги танхимын дотоод тохижилт гэсэн суралцах материаллаг орчинтой холбоотой байна. Эцэг эхийн зөвлөлийг ч энэ чиглэлд анхаарахыг хүүхдүүд хүссэнийг энд дурдъя. Багш, ажилтнуудын харилцаа, хандлагыг өөрчлөх санал хэлсэн хүүхдүүд 8.6%-ийг эзэлж байгаа бөгөөд энэ нь “анхаарах, сонсох, ярилцах, ойлгох,

Зураг 2.13. Сургуулийн бүх зүйл нь таалагддаг гэсэн хүүхдүүд




дэмжих замаар сургуулийн ажилтнууд хүүхдийг хамгаалаасай” гэсэн өмнөх үр дүнтэй холбогдож байна. Өөрчлөх зүйл байхгүй гэж хариулсан хүүхдүүдийг харвал (Зураг 2.15), эрэгтэй хүүхдүүд болон хотын хүүхдүүд бусдаас олонх байна. Түүнчлэн, өөрчлөх зүйл байхгүй гэж хариулсан

Зураг 2.14. Сургуульд өөрчлөх зүйлс



Зураг 2.15. Сургуульд өөрчлөх зүйл байхгүй гэсэн хүүхдүүд



8-9-р ангийнхны тоо бусад ангийнхнаас бага байна. Сургуулийнхаа бүх зүйлд дуртай гэж 8-9-р ангийнхан мөн л бусад ангийнхнаас бага хувьтай хариулсан байсан. Тэгэхээр, 8-9-р ангийнхан дунд дахин ярилцлага хийж, энэ талаар дахин тодруулах, чухам юу тэдний сэтгэл хангалуун бус байдалд нөлөөлж буйг харах нь сонирхолтой хийгээд тэдэнд чиглэсэн арга хэмжээ авахад хэрэгтэй болов уу.

Хамгийн сайн багш гэж хэнийг хэлэх вэ гэсэн асуултад нийт хүүхдийн 42.7% нь хариулаагүй, 1.8% нь мэдэхгүй гэжээ. Харин үлдсэн 55.5%-ийнх нь хариултад шинжилгээ хийж үзье (Хүснэгт 3).


Хүснэгт 3. Сайн багшийн шинжүүд

№	Сайн багшийн шинжүүд	Хувь
1	Ярилцаж ойлголцдог, асуудлыг шийдэж, дэмждэг	20.8
2	Сэтгэлээсээ хичээлээ заадаг	9.1
3	Хүүхэд бүртэй тэгш, ялгаваргүй харилцдаг	7.3
4	Эелдэг, зөв харилцаатай	6.9
5	Сайхан ааштай	2.7
6	Заах арга сайтай	2.1
7	Найз шиг харилцдаг	1.6
8	Зөв хандлага, харилцаатай	1.3
9	Анхаарал халамжтай	0.9
10	Сурагчаа хүндэлдэг, сурагчаараа хүндлүүлдэг	0.7
11	Сэтгэлтэй, хүүхдэд санаа тавьдаг	0.4
12	Үлгэр жишээч, урам өгдөг	0.4
13	Хөгжилтэй	0.4
14	Тайван, хүлээцтэй	0.3
15	Ухаалаг, шийдэмгий	0.3
16	Хамт олонч, эвсэг	0.3

Хүснэгтээс үзвэл, хүүхдүүд сайн багшийн 16 шинжийг нэрлэсэн байгааг багш боловсролын хөтөлбөрт харгалзан үзвэл зүйтэй болов уу. Эдгээр шинжээс хамгийн их нэрлэгдсэн “ярилцаж ойлголцдог, асуудлыг шийдэж, дэмждэг” гэсэн шинжийг нарийвчлан авч үзье (Зураг 2.16).

Ингэхэд, энэ шинжийг нэрлэсэн хөвгүүд охидоос их байгаа бол анги дэвших тусам “ярилцаж ойлголцдог, асуудлыг шийдэж, дэмждэг” энэ шинжийг чухалчилж үзжээ. Түүнчлэн,

Зураг 2.16. Ярилцаж ойлголцдог, асуудлыг шийдэж, дэмждэг багш бол сайн



хөдөөгийн хүүхдүүд хотын хүүхдүүдээс илүү их онцолжээ. Сургуулийн багш нар хүүхдийг хэрхэн хамгаалаасай гэж боддог талаарх асуултад сурагчид ярилцдаг, ойлгодог, тусалдаг гэж хариулсантай сайн багшийн дээрх шинжийг харьцуулахад дүйх хандлагатай байна. Үүнээс, “сайн багш байх”, “хүүхдийг сайн хамгаалдаг багш байх” нь хүүхэдтэй ярилцаж, ойлгохыг хичээдэг, асуудлыг нь шийдэхэд тусалдаг хүн байх гэсэн нийтлэг санаа ажиглагдаж байна.

Энэ бүлэгт бид өсвөр насны хүүхдүүдийн сургуулийн болон амьдралын дадал хэвшлээс гадна сургуулийн орчин дахь хамгааллын асуудлыг тодруулж, хот, хөдөө, хүйс, ангиар ялгаа буй эсэхийг харуулснаас гадна заримд нь учир шалтгааны таамаг дэвшүүлж, дүгнэлт хийлээ. Хавсаргасан хүснэгтээс энэ бүлгийн асуулт түс бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.

3


ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ӨСВӨР
ҮЕИЙНХНИЙ САНАЛ БОДОЛ

Энэ бүлэгт хүүхэд хамгааллын ерөнхий асуудлуудын талаар өсвөр насны хүүхдүүд ямар санал бодолтой байгааг авч үзлээ.


Хүүхдийг хэн хамгаалах ёстой вэ гэсэн асуултад нийт хүүхдийн 42.8% нь бүх хүн гэсэн бол 43.6% нь эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийг нэрлэжээ. Үүнийг байршил, хүйс, ангиар ангилан авч үзэхэд, анхаарал татахуйц зөрөө ажиглагдсангүй (Зураг 3.1). Түүнчлэн, багш, сургуулийн ажилтнууд, 108 тусгай дугаар, хүүхэд хамгаалах байгууллагын ажилтнууд, цагдаа, хүүхэд өөрөө, найз нөхөд, үе тэнгийнхэн гэсэн хувилбарыг бага хувьтай боловч дурджээ. Мэдэхгүй гэсэн хүүхэд нийт хүүхдийн 0.7%, хариулаагүй хүүхэд 2.2% байгааг анхаарч, цаашид хүүхдийг хэн хамгаалах ёстой талаар тэдэнд мэдлэг, мэдээлэл өгөх хэрэгтэй байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Хүүхдийг хэрхэн хамгаалах ёстой талаар хүүхдүүдээс үргэлжлүүлэн тодруулахад, 52.9% нь хүүхдийг анхаарч халамжлах, хайрлах (21.3%); аюулгүй, эрүүл орчин бүрдүүлэх (23.1%); зааж чиглүүлэх, зөвлөх, мэдээлэл өгөх (7.1%); зөв харилцах, үлгэр дуурайл үзүүлэх (1%); хүчирхийлэл, зүй бус үйлдлийг мэдээлэх (0.4%) зэргээр маш тодорхой хариулжээ. Харин 23% нь хамгаалах, гадуурхал, дээрэлхлээс хамгаалах гэсэн ерөнхий хариулт өгсөн бол 6.8% нь мэдэхгүй гэжээ. Хамгийн өндөр хувьтай нэрлэгдсэн хоёр санааг авч үзвэл (Зураг 3.2), охид аюулгүй, эрүүл орчин бүрдүүлэхийг анхаарч халамжлах, хайрлахаас илүүд үзсэн байна. 6-7, 8-9-р ангийнхан анхаарч халамжлах, хайрлахыг хүүхэд хамгаалах арга хэмээн илүүтэй үзсэн бол 10-12-р ангийнхан аюулгүй, эрүүл орчныг чухалд үзжээ. Хот, хөдөөгөөр авч үзвэл аюулгүй, эрүүл орчныг мөн л илүүтэй дурджээ. Сургуулийн орчин дахь хамгааллын тухай өмнөх бүлэгт хүүхэд хамгаалал бол аюулгүй, эрүүл орчин гэсэн санаа бодолтой байгаа нь харагдсан бөгөөд энд мөн л энэ санаа давтагдаж байна. Харин цаашид

Зураг 3.1. Хүүхдийг хамгаалах ёстой хүмүүс



Зураг 3.2. Хүүхдийг хэрхэн хамгаалах тухай санал бодол



судалгаа хийхдээ аюулгүй, эрүүл орчин гэдгийг хүүхдүүд хэрхэн ойлгож байна, тэр нь хүүхдийн нас, хүйс, хот, хөдөөгөөр хэрхэн ялгаатай байгааг тодруулах нь зүйтэй.

Өмнө дурдсанаар, хүүхдийг гадуурхал, дээрэлхлээс хамгаалах ёстой, энэ нь хамгааллын нэг хэсэг гэдгийг хүүхдүүд онцолсон. Үүнийг гүнзгийрүүлэн, хүүхдийг дээрэлхэлтээс хамгаалахын тулд юу хийх ёстойг тэднээс тодруулсан юм. Ингэхэд, хүүхдүүд хүүхдээ ойлгох, ярилцах, сонсох, цаг гаргах, харилцаандаа анхаарах, хүүхдээ чиглүүлэх, зөв төлөвшүүлэх, хараа хяналт тавих гэх мэт маш тодорхой арга замуудыг дурдсан болно (Шигтгээ 2).


Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 42.7% нь хүүхдийг чиглүүлэх, зөв төлөвшүүлэх; хүүхдээ ойлгох, ярилцах, сонсох; хүчирхийлэл, зүй бус үйлдлийг мэдээлэх гэсэн аргыг хүүхэд хамгаалах гол аргад нэрлэсэн. Үүнийг байршил, анги, хүйсээр дэлгэрүүлэн харъя (Зураг 3.3).



Шигтгээ 2

- Хүүхдээ ойлгох, ярилцах, сонсох
- Хүүхдэдээ цаг гаргах, хамт байх
- Эцэг эх харилцаагаа анхаарах
- Сэтгэл санаагаар дэмжих
- Үлгэр дуурайлал үзүүлэх
- Хүчирхийлэл, зүй бус үйлдлийг мэдээлэх
- Зөв зохистой цахим хэрэглээг анхаарах
- Мэдээлэл, зөвлөгөө өгөх
- Тусалж дэмжих
- Хараа хяналт, анхаарал тавих
- Асуудлыг сонсох, шийдвэрлэхэд туслах

Зураг 3.3. Хүүхдийг хамгаалах арга замууд



Ингэхэд, хүүхдээ ойлгох, ярилцах, сонсох аргыг хөвгүүд, хөдөөгийн сурагчид болон 6-7-р ангийнхан илүү онцолжээ. Харин хүүхдийг чиглүүлэх, зөв төлөвшүүлэх нь хамгааллын суурь болохыг эмэгтэй хүүхдүүд, 10-12-р ангийнхан, хотын хүүхдүүд дурджээ. Хамгийн их

нэрлэгдсэн энэхүү гурван аргыг харвал, хүүхдээ ойлгох, ярилцах, сонсох, хүүхдийг чиглүүлэх, зөв төлөвшүүлэх нь хүмүүжилтэй холбоотой суурь асуудал байгаа бол харин аливаа зүй бус үйлдэл, хүчирхийллийг мэдээлж байх нь хүүхдийг дээрэлхэлтээс хамгаалах маш тодорхой арга

болгон авч үзсэн байна. Дээрэлхэлт нь үндсэндээ хүүхэд хооронд гардаг асуудал тул хүүхдийг чиглүүлэх, зөв төлөвшүүлэх асуудлыг хөндсөн нь асуудлын суурь шалтгаанд хандсан хэрэг болжээ. Эдгээр хариултаас, хүүхэд бол өөрт хамааралтай асуудлаар санаа бодлоо илэрхийлж, үнэ цэнтэй мэдээлэл өгч чадахуйц субъект гэдэг нь харагдаж буйг энэ дашрамд онцолъё.

Үргэлжлүүлээд, эцэг эхчүүд хүүхдээ яг хэрхэн хамгаалах ёстой вэ гэсэн асуултад хүүхдүүд мөн л шигтгээ 2-т дурдсан арга замуудыг нэрлэсэн бөгөөд тэдгээрээс хүүхдээ ойлгох, ярилцах, сонсох арга (26.2%)-ыг хамгийн ихээр дурдсан байна. Хүүхдийг хэн, яаж хамгаалах, үүн дотор дээрэлхэлтээс хүүхдийг хэрхэн хамгаалах ёстой вэ гэсэн асуултуудад “хүүхдийг ойлгох, ярилцах, сонсох” гэсэн хариулт нийтлэг ажиглагдаж буй. Хүүхдээ сонс, ярилц, тэдний нас, сэтгэхүйн онцлогийг ойлгож, түүнд тохируулж харилцаарай гэх мэргэжилтнүүдийн зөвлөгөө үнэн болох нь эндээс харагдана. Дашрамд дурдахад, Хүүхдийг Ивээх Сан хүүхдийнхээ нас, сэтгэхүйн онцлог, хэрэгцээг мэдэх, ойлгох, сонсох замаар зөв заавар чиглүүлэг, удирдамжаар хангах аргачлал бүхий “Хүмүүжлийн эерэг арга” арга зүйг Монгол Улсад нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр зүтгэл гаргадаг нь хүүхдийн хэрэгцээнд суурилдаг болох нь эндээс мөн тодорхой байна.

Гэр бүлийн орчин дахь харилцаа нь хүүхэд хамгааллын суурь болох учраас гэр бүлийн гишүүд, үүн дотор эцэг эх, ах эгч, эмээ өвөө хүүхэдтэй хэрхэн харилцах ёстой талаар


хүүхдүүдээс тодруулсан юм. Гэр бүлийн гишүүн хэн байхаас үл хамааран эелдэг найрсаг, дотно хийгээд нээлттэй харилцаа чухал болохыг хариулт өгсөн 10 хүүхэд тутмын 5-6 нь онцолжээ (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хүүхэд тогтоох харилцаа

Гэр бүлийн гишүүд	Хүүхэдтэй тогтоох харилцаа	Хувь
Эцэг эх	Дотно, дулаахан, найрсаг, эелдэг	47.7
	Нээлттэй, ойлголцсон	15.4
Ах эгч	Илэн далангүй, дотно, нээлттэй	62.7
	Эвтэй, зөрчилгүй	9.4
Эмээ өвөө	Нээлттэй, илэн далангүй	34.6
	Эелдэг, зөөлөн, хүндэтгэлтэй, өгөөмөр	28.3

Гэр бүлийн гишүүдээс гадна нийгмийн бусад орчинд хамаарах дэлгүүрийн худалдагч, орцны жижүүр, автобусанд хамт зорчигчид хүүхэдтэй найрсаг, зөв боловсон, хүндэтгэлтэй харилцах ёстойг 10 хүүхэд тутмын 6-8 нь дурджээ. Үргэлжлүүлээд, олон нийтийн газарт хүнд байдалд ороход эргэн тойрны хүмүүс тусалдаг эсэх талаар лавлахад, нийт оролцогчдын 88% нь хариулсны 48.4% нь үгүй, харин 39.6% нь тийм гэсэн байна. Үгүй гэж хариулсан хүүхдүүдийн дунд эмэгтэй хүүхдүүд, 8-9-р ангийнхан, түүнчлэн хотын хүүхдүүд олонхыг эзэлж байна (Зураг 3.4).

Зураг 3.4. Олон нийтийн газарт бусад хүн тусалдаг эсэх



Цахим орчинд хүүхдэд юу хамгийн аюултай болохыг тодруулахад, 36.8% нь хуурамч хаяг, 8.9% нь цахим залилан, луйвар, 8% нь хакер, вирус, цахим халдлагыг онцгойлон нэрлэжээ. Мөн бага хувьтай боловч хуурамч мэдээлэл, цахим дээрэлхэлт, цахим гэмт хэрэг, донтолт зэрэг асуудлыг ч дурдсан байна.


Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс цахим орчны эрсдэлээс өөрийгөө хамгаалах аргыг мэдэх талаар лавлахад, 20.6% нь мэдэхгүй гэсэн бол 50.7% нь мэднэ гэсэн ч тодорхой арга нэрлээгүй байна. Харин 11.7% нь цахим орчинд хувийн мэдээллээ хамгаалах талаар мэднэ гэсэн нь цахим орчинд өөрийгөө хамгаалах аргуудыг нэрлэсэн хүүхдүүдээс хамгийн олон хувийг эзэлж байна. Мэдэхгүй гэсэн хүүхдүүдийг нарийвчлан харвал, 6-7-р ангийнхан бусад ангийнхнаас бага мэдлэгтэй байгаа бол сонирхолтой нь хотын хүүхдүүд хөдөөгийнхөөс бага мэдлэгтэй гэж хариулсан байна (Зураг 3.5).

Цахим орчинд хүүхдийг хэн хамгаалах ёстой талаарх асуултад нийт оролцогчийн 63% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 38.3% нь эцэг эхийг нэрлэсэн бол 8.1% нь хуулийн байгууллага, 3.4% нь насанд хүрэгчид хэмээсэн байна. Харин 6.2% нь мэдэхгүй гэжээ.


Цахим орчинд хүүхдийг хэрхэн хамгаалах талаарх судалгаанд оролцогчдын саналыг мөн тодруулахад 37.5% нь хариулт өгсөн. Ингэхэд, нууцлал, мэдээлэл хамгаалалтын талаар заах, ёс зүйтэй цахим харилцааг баримтлах, үлгэрлэх, мэдлэг мэдээлэл түгээх, контент, платформыг хянах гэсэн аргыг нэрлэсэн байна. Эдгээрээс цахим орчинд өөрийгөө хамгаалах чадварыг хүүхдэд зааж сургах (10.8%) аргыг хамгийн олон хүүхэд онцолжээ. Үүнийг нарийвчлан харвал (Зураг 3.6), хүйсээр төдийлөн ялгаагүй бол хотын хүүхдүүд, 8-9-р ангийнхан энэ асуудлыг бусдаас илүүтэй авч үзжээ. Өмнө дурдсанаар, хүүхдүүд цахим орчинд өөрийгөө хамгаалах аргуудыг мэдэхгүй гэсэн байсан нь ийм чадварыг хүүхдэд олгох хэрэгтэй гэсэн үр дүнтэй нийцэж байна.

Хурдан морь унадаг хүүхдүүдийг хэн хамгаалах вэ гэсэн асуултад нийт хүүхдийн 45.2% нь хариулсан бөгөөд үүний 21.2% нь уяач, морины эзнийг онцолсон бол 18% нь эцэг эх, асран хамгаалагчийг нэрлэжээ. Цөөн хувь нь төрийн байгууллага, уралдаан зохион байгуулагчийг дурдсан байна. Эдгээр хүүхдийг хэрхэн хамгаалах талаар тодруулахад, нийт хүүхдийн

Зураг 3.5. Цахим орчинд өөрийгөө хамгаалах талаар мэдэхгүй хүүхдүүд




Зураг 3.6. Цахим орчинд өөрийгөө хамгаалах чадварыг хүүхдэд олгох хэрэгтэй гэсэн хүүхдүүд



40% нь хариулсан. Ингэхэд, хамгаалалтын хувцас хэрэглэх, морины уралдаанд хориг тавих, даатгал, хуулийн хариуцлагыг сайжруулах, насны хязгаар тогтоох, цалин хөлсийг нь сайн олгох зэргийг нэрлэсэн байна.

Хүүхдийн эрх зөрчигдвөл хэн хамгаалах талаар төгсгөлд нь лавлахад, нийт хүүхдийн 84.3% нь хариулсан. Ингэхэд, хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагч, багш, сургууль, хүүхэд хамгааллын байгууллага, тусгай дугаар, цагдаа, шүүх, бусад хүмүүс, хүүхэд өөрөө гэсэн хувилбарыг дурдсан. Эдгээрээс хүүхэд хамгааллын байгууллага, тусгай дугаар, дараа нь эцэг эх, асран хамгаалагч, багш, сургууль хамгийн өндөр хувьтай байна. Тэдгээрийг байршил, хүйс, ангиар ялган харуулъя (Зураг 3.7).

Зураг 3.7. Хүүхдийн эрхийг хамгаалуулахаар хандах хүмүүс



Зургаас харахад, хүүхэд хамгааллын байгууллага, тусгай дугаарыг эрэгтэй хүүхдүүд, 6-7-р ангийнхан, хөдөөгийн хүүхдүүд бусдаас илүүтэй онцолжээ. Харин эцэг эх, асран хамгаалагчийг эмэгтэй хүүхдүүд, 8-9-р ангийнхан онцлон авч үзжээ. Багш, сургуулийг хамгийн бага онцолсон нь 10-12-р ангийнхан байна.

Энэ бүлэгт бид өсвөр насны хүүхдүүдийн хүүхэд хамгааллын ерөнхий асуудлуудын талаарх санал бодлыг тодруулж, хот, хөдөө, хүйс, ангиар ялгаа буй эсэхийг харуулснаас гадна заримд нь учир шалтгааны таамаг дэвшүүлж, дүгнэлт хийлээ. Хавсаргасан хүснэгтээс энэ бүлгийн асуулт тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

“Өсвөр үеийнхний дуу хоолой” цуврал судалгааг энэ удаад өсвөр насны хүүхдүүдийн амьдралын хэвшил, нөхцөл байдал, хамгаалал гэсэн сэдвийн хүрээнд хийлээ. Энэхүү гурав дахь цувралыг сургуулийн орчинд хүүхэд хамгааллын хамтын механизмыг бүрдүүлэх зорилго бүхий “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд гүйцэтгэсэн болно. “Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын хамтын механизм” хэмээх ойлголтыг доорх зурагт дүрслэв.



Тайлбарлавал, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу болон нөхөн сэргээх арга хэмжээ бүхий хүүхэд хамгааллын механизмыг сургуулийн орчинд бүрдүүлэх, энэ механизм нь хамтын байх, хамтын механизмын тулгуур нь хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн багш, ажилтнууд байх гэсэн санаа.

Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын хамтын механизмыг бүрдүүлэн бэхжүүлэхэд түүний тулгуур болох хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн багш, ажилтнуудын мэдлэг, хандлага, үйлдэл чухал бөгөөд тэдгээрийг механизмын өмнө өөр өөрсдийнх нь хүлээсэн үүрэг, оролцооных нь дагуу чадавхжуулах нь гол асуудал билээ. Иймээс ч дээр дурдсан төслийн хүрээнд тулгуур талуудыг сургах, чадваржуулах ажлуудыг хийж ирсэн байна. Харин судалгааны үр дүнд үндэслэн цаашид анхаарах, магадгүй дээр дурдсан механизмын тулгуур оролцогчдод хандсан ямар арга хэмжээ авах ёстой талаар хоёр бүлэг санаа дурдъя:

Нэг. Өсвөр насны хүүхдүүдийн амьдралын хэвшил: Нойр, өглөөний цай, шингэний хэрэглээ, ариун цэвэр, амралт

- Өсвөр насны хүүхдүүд эрдэмтдийн зөвлөж буйгаас даруй 3 цагаар бага унтаж байна. Ийм байдал удаан үргэлжлэх нь тэдний суралцах чадвар, эрүүл мэнд, урт хугацаандаа тэдний амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэл бий. Өсвөр насны хүүхдүүд дунд 6-7-р анги буюу 12-13 настай хүүхдүүд бусад хүүхдүүдтэй харьцуулахад хамгийн орой унтаж, хамгийн эрт босох хандлагатай байна. Улмаар

